ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо 1	Хувийн жин 2
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт /3/ (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх /4/			1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх /5/			0.5	5
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх /6/		1	10
			Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал /7/		1	10
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал /8/		0	
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал /9/		1	10
Хэсгийн оноо					4.5 оноо	45 оноо
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх /10/ *(гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*			1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал /11/			0	
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал /12/			1	10

Хэсгийн оноо				2 оноо	20 оноо
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал /13/		1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал /14/ *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал /15/		0	
Хэсгийн оноо				2 оноо	20 оноо
Үнэлгээний нийт оноо, хувь				8.5 оноо	85 оноо

---oOo---


БАТЛАВ.
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА,
ХУРАНДАА А.НАМСАМАНД

2025 оны 02 дугаар сарын 11 -ны өдөр

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д		Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх түвшин	Хугацаа	Хариуцах ажилтан
Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар					
1	1	“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийн сахилга ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн дүрмийн төслийг боловсруулж, албан хаагчийн ёс зүйн хариуцлага, сахилгын шийтгэл ногдуулах төрлийг тусгаж боловсруулна.	I улирал	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Ёс зүйн дэд хороо
2	2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа албан, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгж Ёс зүйн дэд хорооны гишүүдийг сонгож, бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.4.40-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батална.	I улирал	ШШГЕГ-ын Ёс зүйн дэд хороо, харьяа албан, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийн дарга
3	3	Албан хаагчийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдөн ажиллахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх, таниулах ажлыг зохион байгуулах.	Албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн агуулга, хэм хэмжээ, бүлэг тус бүрээр шинэлэг оновчтой хэлбэрээр сургалт зохион байгуулна.	I-IV улирал	Соён гэгээрүүлэх хэлтэс, Харьяа албан, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийн Ёс зүйн дэд хороо

					/цаашид “Ёс зүйн дэд хороод” гэх/
4	4	Алба хаагчийг албан тушаал дэвшүүлэх, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, томилоход ёс зүйн шалгуурыг харгалзан үзэх.	Алба хаагчийг төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг мөрдүүлэх ажлын байран дахь сургалтыг тогтмолжуулах, зөв харилцаа хандлага, хариуцлагатай, ёс зүйтэй алба хаагчдыг бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	I-IV улирал	Ёс зүйн дэд хороод
Хоёр.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа талаар					
5	1	Ёс зүйн хорооноос баталсан агуулга, сэдвийн хүрээнд алба хаагч бүрийг ёс зүйн багц цагийн цахим сургалтад тухай бүр хамруулах.	Алба хаагчдын ёс зүйн багц цагийн цахим сургалтыг агуулга, сэдвийн хүрээнд зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллана.	I-IV улирал	Соён гэгээрүүлэх хэлтэс, Ёс зүйн дэд хороод
6	2	Алба хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан тухай өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх.	Ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэн, шалган шийдвэрлэж, Ёс зүйн дэд хорооны хуралдаанаар хэлэлцэн дүгнэлтийг талуудад мэдэгдсэн байна.	Хуулийн хугацаанд	Ёс зүйн дэд хороод
7	3	Байгууллагын цахим хуудаст Ёс зүйн дэд хорооны цэс байршуулан ёс зүйн хариуцлага хүлээсэн алба хаагчийн зөрчил, мэдээллийн талаар байршуулах	Байгууллагын цахим хуудаст Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүний мэдээлэл, ёс зүйн хариуцлага хүлээсэн тоо, мэдээ, тайланг тухай бүр байршуулсан байна.	I-IV улирал	Ёс зүйн дэд хороод
8	4	Хамт олноо манлайлан сахилга бат, ёс зүйтэй, зөв үлгэр дуурайлалтай ажилласан алба хаагчийг урамшуулах	Байгууллага хамт олондоо зөв үлгэр дуурайлал үзүүлж буй ажлын хариуцлага, сахилга бат, ёс зүйтэй алба хаагчийг шагнаж урамшуулсан байна.	I-IV улирал	Ёс зүйн дэд хороод
Гурав.Дүн шинжилгээ,судалгааны ажлын талаар					
9	1	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны талаар иргэд, олон нийтээс сэтгэл ханамжийн судалгааг авах.	Ёс зүйн дэд хороо алба хаагчийн үйл ажиллагаа, ёс зүйн талаар иргэд, олон нийтээс сэтгэл ханамжийн судалгаа авч, дүгнэлт гаргасан байна.	IV улирал	Ёс зүйн дэд хороод



10	2	Алба хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан шалтгаан, нөхцөлийг судалж, нөлөөлж буй хүчин зүйлийг судлан зөрчлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.	Алба хаагчдын ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйл, зөрчлийг бууруулах, арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.	IV улирал	Ёс зүйн дэд хороод
11	3	Алба хаагчдын гаргасан, эсхүл үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг тодорхойлох дүн шинжилгээ хийх.	Алба хаагчдын ёс зүйн зөрчилд өртөх болсон суурь шалтгааныг судалж, эрсдэлийг тооцох, дүн шинжилгээг хагас, бүтэн жилээр хийсэн байна.	2025 оны 6, 12 дугаар сард	Ёс зүйн дэд хороод
12	4	Ёс зүйн дэд хороодын хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, алба хаагчийн ёс зүйн хариуцлагын мэдээг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулах.	Ёс зүйн хариуцлага, сахилга шийтгэлийн нэгтгэсэн мэдээ, тайланг даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулна.	2025 оны 6, 12 дугаар сард	Ёс зүйн дэд хороо

---oOo---

ШҮҮХИЙН ШИНЖЛЭХ
ҮЙЛЧЛЭГЧ ЕРӨНХИЙ
ГАЗАР
1765
ХУУЛБАР ҮНЭН
2025. 12. 30

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
ЁС ЗҮЙ ДЭД ХОРООНЫ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Нэг.Товч танилцуулга

Байгууллагын хэмжээнд алба хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар нийт 9 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд-4, бичгээр-5 ирүүлсэн байна. Үүнээс:

-иргэний хүсэлтэд анхааралтай хандаж, хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд хариу өгөөгүй-6;

-бусдын бие эрхтний онцлогийг зохисгүй үг, үйлдлээр илэрхийлэхийг цээрлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний өөрийгөө илэрхийлэх үйлдлийг даган дуурайхгүй байх, ёс бус үг, хэллэг хэрэглэсэн-3.

2025 оны байдлаар Ёс зүйн дэд хорооны хуралдаанаар 3 алба хаагч Ёс зүйн дэд хорооны дүгнэлтээр ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдоогүй, 6 алба хаагч ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдож, олон нийтийн өмнө уучлалт гуйхыг үүрэг болгох-2, хамт олноос уучлал гуйх-4 алба хаагч сайн дураараа хариуцлага хүлээсэн.

Ёс зүйн дэд хорооны хуралдааныг 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр нэр бүхий 13 алба хаагчийн ёс зүйн зөрчил гаргасан эсэх, 06 дугаар сарын 26-ны өдөр Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн нэр бүхий алба хаагчид согтуурлах ундааны зүйл хэрэглэх ёс зүйн зөрчил гаргасан эсэх, 10 дугаар сарын 29-ний өдөр Дорноговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хурандаа Т.Хасбаатарын ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар тус тус хуралдаан зохион байгуулж, Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргад танилцуулан ажилласан.

Түүнчлэн, шинээр томилогдсон алба хаагчдыг сурган дадлагажуулах, ажлын орчин нөхцөлд дасан зохицох боломжийг бүрдүүлэхээр “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2024-2025 онд зохион байгуулах сургалт, хөгжлийн хөтөлбөр”-ийн дагуу сургалтад хамруулж, үр дүнг тооцохын зэрэгцээ хамт олондоо дасан зохицох, зөв хандлагыг төлөвшүүлэх, ёс зүйг эрхэмлэх зэрэг дадалд чиглүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.

Байгууллагын хэмжээнд ёс зүйн зөрчлийг гаргаж буй алба хаагчдын шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийхэд хувь хүний ажлын хариуцлага, хувийн зохион байгуулалт, сахилга бат, ажлын цаг ашиглалт хангалтгүй, алба хаагч хоорондын харилцаа, уур бухимдалтай байдал, гэр бүлээс хол амьдардаг, хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, ойлголцол муу, албан тушаал тодорхойлолт болон хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ ухамсарладаггүй зэрэг байдал нөлөөлж байна.

Иймд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажил арга хэмжээ зохион байгуулах, ингэхдээ зөвхөн сургалтад хамруулахаас гадна алба хаагч, хувь хүнд чиглэгдсэн ажлаас халшрах хам шинжийг арилгах, гэр бүлийн харилцааг тогтвортой байлгах, хорт зуршлаас татгалзах талаар нийгэм, сэтгэлзүйн үйлчилгээг үе шаттай зохион байгуулан ажиллахаар байна.

Хоёр.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын 2.4-т заасны дагуу “Ёс зүйн дэд хороо”-ны гишүүнд олонхын санал авсан алба хаагчдыг сонгож, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2025 оны А/325 дугаар тушаалаар “Ёс зүйн дэд хороо”-г 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 2025 оны 06 дугаар сард “Ёс зүй, сахилга хариуцлагаар тэргүүлье” 14 хоногийн аян зохион байгуулж, Цэргийн тангараг давтах үйл ажиллагаагаар дүрс бичлэг хийж байгууллагын Фэйсбүүк хуудаст нийтлэн, нийт албан хаагчдад өргөсөн тангарагтаа үнэнч байх, байгууллагын алба хаагчийн тангарагт ёс зүйг эрхэрхэмлэн сахих соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгууллаа.

Байгууллагын хэмжээнд зохион байгуулсан “Ёс зүй, сахилга хариуцлагаар тэргүүлье” аяны ажлын хүрээнд Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүн, Удирдлагын Академийн багш доктор (Ph.D) Ч.Эрдэнэчимэгтэй хамтран 2025 оны “Ёс зүйг дээдэлсэн байгууллагын соёлыг бүрдүүлэхэд таны оролцоо” сэдэвт сургалтыг цахим болон танхимаар зохион байгуулсан.

Мөн “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, сахилгын зөрчлийн ялгаа” “Байгууллагын соёл” сэдвээр Ёс зүйн хорооны ажлын албаны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүүтэй хамтран иргэд, олон нийтэд хууль, эрх зүйн мэдээлэл хүргэх зорилгоор “Хөтөч” подкастыг бэлтгэн, байгууллагын цахим хуудаст байршуулж, байгууллагын албан хаагчдад сурталчлан мэдээлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Ёс зүйн дэд хороо нь тайланг улирал бүр нэгтгэн Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хороонд хүргүүлж ажилласан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бүтэц хүний нөөцийн талаарх мэдээлэл нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд хуульд заасан нийтэд илэрхий мэдээллэх 68 төрлийн мэдээ, мэдээллийг Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас болох www.gov.mn, www.shilen.gov.mn, Ёс зүйн дэд хорооны хийж хэрэгжүүлж буй ажлыг цахим хуудаст тус тус байршуулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд үнэлүүлж ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдын 2025 оны ажлын гүйцэтгэлийн үнэлгээг Төрийн байгууллагын нэгдсэн www.gov.mn цахим хуудаст байршуулан иргэд, олон нийтэд нээлттэй болгосон.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Ерөнхий газрын даргын зүгээс удирдах ажилтны зөвлөгөөнөөр ёс зүйн манлайллыг удирдах албан тушаалтнаас үлгэрлэх нь зүйтэй гэсэн зарчмын байр суурийг илэрхийлж, тодорхой үүрэг чиглэлийг өгсөнтэй холбогдуулан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, анхаарах асуудал” сэдвийн хүрээнд Төрийн албаны Ёс зүйн хорооны ажлын албаны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүү эрхлэн явуулсан. Сургалтад нийт 81 удирдах албан тушаалтан /танхим-41, цахим-40/-ыг хамруулсан.

Удирдлагын академийн Инновац хөгжлийн албатай хамтран алба хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэх Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Сургалтад Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга болон харьяа 15 салбар нэгжийн ёс зүйн дэд хорооны дарга нарыг хамруулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/285 дугаар тушаалаар "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2024-2025 онд зохион байгуулах сургалт, хөгжлийн хөтөлбөр"-ийн хүрээнд Ёс зүйн чиглэлээр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм, Хүний эрх, Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Ёс зүй, харилцаа, хандлага зэрэг сэдвээр төв байгууллага болон харьяа 55 салбар нэгжийн 13355 /давхардсан тоогоор/ алба хаагчийг 594 цагийн сургалтад хамруулсан байна.

Мөн салбар нэгжүүд нь нийт алба хаагчдаас ажилдаа хариуцлагатай хандах үүднээс албаны нууцыг хадгалах, хамгаалах, нууц задруулахгүй байх баталгааг авсан байна. Харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, алба хаагчдын үүрэг гүйцэтгэлийг чанаржуулах, харилцаа, хандлага, ёс зүйн манлайллыг төлөвшүүлэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхээр "Харуулчдын зөвлөгөөн"-ийг жил бүр зохион байгуулж байна.

2.3.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Ёс зүй дэд хороо нь "Төрийн албаны тухай хууль", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль", "Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хууль", "Ёс зүйн дэд хорооны ажиллаж журам", Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/183 дугаар тушаалаар баталсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйлчилгээний стандарт", "Хөдөлмөрийн дотоод журам", Цэргийн албаны нийтлэг дүрэм болон бусад хууль тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ёс зүйн дэд хороодод байгууллагын 2025 онд дэвшүүлсэн зорилт болон алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйн зөрчлийг бууруулах, Ёс зүйн дэд хороодын ажлыг тогтмолжуулах, сахилга, ёс зүйн зөрчилд улирал бүр дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг судлах талаар 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 2/426, 04 дүгээр сарын 14-ний өдрийн 2/1052, 04 дүгээр сарын 16-ны өдрийн 1/1087, 04 дүгээр сарын 22-ны өдрийн 05-2/1161 дүгээр албан бичгээр үүрэг хүргүүлж, тухай бүр мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажилласан.

"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилгын дүрэм", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ёс зүйн дүрэм"-ийн төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх Ёс зүйн хороо, Авлигатай тэмцэх газраас санал авсан. Тус дүрэмд тусгах саналыг нэмж боловсруулан 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 2/2309 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2024 оны А/285 дугаар тушаалаар "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2024-2025 онд зохион байгуулах сургалт, хөгжлийн хөтөлбөр"-ийг баталж, ёс зүйн чиглэлээр тодорхой багц цагийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүллээ. Тухайлбал, "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм", "Хувь хүний хөгжлийн өсөлтийн сэтгэлгээ", "Архины хор нөлөө", "Хувь хүний манлайлал, ёс зүй", "Төрийн албан хаагчийн ёс зүйн манлайлал", "Харилцаа ба хандлага", "Хүний эрх", "Авилга, ашиг сонирхлын

зөрчлөөс урьдчилан сэргийлэх", "Байгууллагын соёл, харилцаа хандлага", "Байгууллагын соёл, ажлын хандлага, зан үйл", "Карьер менежмент", "Өөрийгөө удирдан зохион байгуулах чадвар", "Хандлага ба өөрчлөлт", "Ажлаас халшрах хам шинж", "Ёс зүй, харилцаа, хандлага" зэрэг сэдвээр төв байгууллага болон харьяа 55 салбар нэгжийн 13355 /давхардсан тоогоор/ алба хаагчийг 594 цагийн сургалтад хамруулсан.

Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжийн хүрээнд хорих, баривчлах, цагдан хорих үйл ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, алба хаагчдын мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаатай хамтран 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр "Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны тухай ойлголт, мэдлэг, мэдээлэл олгох" сэдвийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хавсран гүйцэтгэгч, нийт 88 алба хаагчдад Цахим сургалтыг зохион байгуулсан.

2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Монгол Улсын ёс зүйн хороотой хамтран Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн дарга, дэд профессор А.Алтанзулыг урьж, "Төрийн албан хаагчийн сахилга, ёс зүйн зөрчил ба түүний онцлог" сэдвээр хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийн нийгмийн ахлах ажилтан, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч болон тус албан тушаалыг хавсран гүйцэтгэгч нийт 122 алба хаагчдад цахим сургалтыг зохион байгуулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 2025 онд сургалтын чиглэлээр нийт 3154 цагийн сургалтад давхардсан тоогоор 60,185 алба хаагч хамрагдсанаас ёс зүйн сэдвээр төв байгууллага болон харьяа 55 салбар нэгжийн 13355 /давхардсан тоогоор/ алба хаагчийг 594 цагийн сургалтад хамруулсан нь нийт сургалтын 19 хувийг эзэлж байна.

Мөн байгууллагын салбар нэгжүүд darkhan.cd.gov.mn, bhzh.cd.gov.mn цахим хуудас, "Шударга ёс, хөгжил дэвшилд" мэдээллийн самбарт албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах цагийн хуваарийг байршуулсан.

Ёс зүйн зөрчилгүй бусдыгаа манлайлан ажиллаж буй алба хаачдыг хамт олны өмнө сайшаах, "Талархалын бичиг" мөнгөн шагналаар шагнаж урамшуулан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын "Хөдөлмөрийн дотоод журам"-д заасны дагуу салбар нэгжүүд нь "Ёс журмын эргүүл"-ийн хуваарийг баталж хэвшүүлээд байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	**Бэрхшээл:**
Шинээр томилогдсон алба хаагчдыг дагалдуулан дадлагажуулах, ажлын орчин нөхцөлд дасан зохицох боломжийг бүрдүүлэхээр "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад 2024-2025 онд зохион байгуулах сургалт, хөгжлийн хөтөлбөр"-ийн дагуу сургалтад хамруулж, үр дүнг тооцохын зэрэгцээ хамт олондоо дасан зохицох, зөв хандлагыг төлөвшүүлэх, ёс зүйг эрхэмлэх зэрэг дадалд чиглүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна.	Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7-д "төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ.." гэж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 273 дугаар зүйлийн 273.2.5-д "албан үүргээ гүйцэтгэх болон албаны бэлэн байдал зарласан үед, ажлын байранд болон дүрэмт хувцас өмссөн үедээ согтууруулах ундаа хэрэглэх" гэж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.8-д "албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх" гэж тус тус заасан

	бөгөөд сахилгын зөрчил, ёс зүйн зөрчил давхардсан байгаа нь хууль хэрэглээний ойлголтын зөрүүтэй байна.

Санал:

Ёс зүйн дэд хороодын гишүүдийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор ёс зүй, хууль эрх зүйн чиглэлээр мэргэшсэн гадаад, дотоодын мэргэжилтэн уриж төрийн байгууллагуудын хамтарсан сургалтыг зохион байгуулах.

ДАРГА, ХУРАНДАА А.НАМСАМАНД

ТАНИЛЦСАН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА,
ХУРАНДАА С.ЛХАГВАСҮРЭН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА Д.САНДАГ

2025 оны 12 дугаар сарын 25